



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 708

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад  
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтооолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нэхсөн боловч цаашид ашиглаж болох 1 нэрийн 169,750,000.00 (нэг зуун жаран есөн сая долоон зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 96,000,000.00 (ерэн зургаан сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн  
20.8 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, УЛДЭГДЭЛ ЕРТӨГТҮЙ ХӨРӨНГИЙН  
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Нэг бурийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуrimтлаидсэн эзлэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ /төгрөг/ Ашиглах жил	Шинэчлэн тогтоох үнэ /төгрөг/ Нэг бурийн үнэ /төгрөг/ Нийт дүн /төгрөг/	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Ниссан патрол Y62, 38-86 УБҮ (арал-jn1tanyu627z0020314)	2014.09.01	169,750,000.0	1	169,750,000.00	6	96,000,000.00	96,000,000.00
	Нийт дүн				169,750,000.00 (нэг зуун жаран есэн сая долоон зуун тавин мянган)		96,000,000.00 (ерэн зураган сая)	Улсын бүртгэлийн өрөнхий газар